



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/10

Мөрөн сум

Үйл ажиллагааны үнэлгээг баталж,
урамшуулал олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.3, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 31 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны ээлжит 9 дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн 2018 оны үйл ажиллагааны үнэлгээг нэгдүгээр хавсралтаар, байгууллагын үйл ажиллагааны үнэлгээг хоёрдугаар хавсралтаар, шалгарсан агентлаг, байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний урамшуулалд олгох зардлыг гуравдугаар хавсралтаар, тус тус баталсугай.

2. Агентлаг байгууллагын 2018 оны үйл ажиллагааны үнэлгээгээр тэргүүлсэн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагад олгох урамшууллын 3.644.000 (Гурван сая зургаан зуун дөчин дөрвөн мянган) төгрөгийг аймгийн Засаг дарга ерөнхий данснаас гаргахыг аймгийн ерөнхий санхүүч (Ц.Мөнхтуяад), агентлаг, байгууллагын дарга нарын цалингийн урамшууллыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 31 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 10.5.4 заасны дагуу тухайн байгууллагын төсвөөс зарцуулахыг нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД